

“СОНСГОЛОН” ДЭД ТӨВИЙН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, БАРИЛГАЖИЛТЫН ТӨСӨЛ БОЛОЛВСРУУЛСАН АЖЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

Үндэслэл:

НЗД-ын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/524 дүгээр захирамжаар баталсан “Сонсголон” дэд төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах №2021/06 дугаартай зургийн даалгавар дагуу Хот байгуулалт хөгжлийн газрын захиалгаар Хот төлөвлөлт, судалгааны институт барилгажилтын төслийг боловсруулсан.

Зорилго:

Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжих зорилтын хүрээнд иргэд олон нийтэд үзүүлэх төрийн болон нийгмийн үйлчилгээний тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх, дэд төвийн орон зайн төлөвлөлт, эдийн засаг хөрөнгө оруулалтын үр ашгийн тооцоог боловсруулах.

Тус ажлын хүрээнд 2022.06.09-ны хурлаар захиалагч байгууллагаас 4 санал, иргэд олон нийтийн хэлэлцүүлэгээс 39 санал, 2022.10.05-нд МАЭ-ийн дэргэдэх Хот төлөвлөлт архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 8 дугаар хурлаар ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг танилцуулж 7 санал зөвлөмж авч тусгасан.

